

**Аймгийн удирдах ажилтнуудын 2023 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн
шуурхай зөвлөгөөнөөс өгсөн үүрэг, даалгавар**

2024.01.08

№	Үүрэг даалгавар	Хэрэгжүүлэх хугацаа	Биелэлт	Хэрэгжилтийн хувь
1	Баярын өдрүүдэд аймгийн хариуцлагатай жижүүрийн үүргийг байгууллагын удирдлагууд хуваарийн дагуу өөрийн биеэр хийж гүйцэтгэх, хариуцлагатай ажиллах	2023.12.28- 2024.01.02	Аймгийн Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн “Хариуцлагатай жижүүр томилох тухай” А/383 дугаар захирамжаар Шинэ жилийн баярын өдрүүдэд хариуцлагатай жижүүрийн үүргийг 16 удирдах албан тушаалтан гүйцэтгэхээс 10 албан тушаалтан үүрэг гүйцэтгэсэн. Цагдаагийн хэлтэс, Онцгой байдал, Эмнэлгийн хувьд тайван буюу ноцтой гарсан гэмт хэрэг, гамшгийн дуудлага ирээгүй, Эрүүл мэндийн салбарын хувьд ханиад, халуурсан, яаралтай тусламжийн нийт 71 дуудлага ирсэнээс 43.6 хувь нь ханиад томууны дуудлага байна. УсДу ОНӨААТҮГ-т ирсэн дуудлага ирээгүй. Цахилгаан хангамжийн хувьд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр Хорихын 75 байрны 1 орцонд хүчдэл унасныг шуурхай засварласан. Жижүүрийн үүрэг гүйцэтгээгүй удирдах албан тушаалтан: /ГХБХБГ-ын дарга Б.Отгончимэг, УБХ-ийн дарга З.Баяндугар, СХЗХ-ийн дарга Л.Жамбаасүрэн, АТТ-ийн дарга Н.Мөнхнаран, ГБХЗХГ-ын дарга Ц.Оюунбилэг, ЦҮХ-ийн Э.Энх-Орчлон/ нар үүрэг гүйцэтгэсэн тухай тэмдэглэл байхгүй тул үүрэг гүйцэтгээгүйд тооцсон.	90
2	Аж ахуйн нэгж, байгууллагууд хариуцсан нийтийн эдэлбэр газрын 50м хүртэлх талбайн хог хаягдал, цас, мөсийг цэвэрлэх, хартиргаа, гулгаа үүсэхгүй байх тал дээр анхаарч ажиллах	2023.12.28	2023 оны 12 сарын 26-ны өдрөөс 2024 оны 01 сарын 05-ны өдрийн хооронд 21 байгууллага нийтийн эдэлбэр газрын 50м хүртэлх талбайн хог хаягдал, цас мөсийг цэвэрлэсэн. Цэвэрлэгээнд гарсан ААНБ-ын нэрс: Сүмбэр сумын ЗДТГ, Боржигин өв музей, Гэр бүл,хүүхэд, залуучуудын хөгжлийн төв, Нэгдсэн эмнэлэг, Нийтийн номын сан, Цагдаагийн хэлтэс, Стандарт хэмжил зүйн газар, Эрүүл мэндийн газар, Ус, цаг уур,орчины шинжилгээний газар, Мал эмнэлэгийн газар, Сум дундын ойн анги, Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын	50

			<p>газар, Насан туршийн боловсролын төв, Соёл урлагийн газар, Улсын бүртгэлийн хэлтэс, Аймгийн Засаг даргын Тамгын газар, Санхүү хяналт, дотоод аудитын газар, Тагнуулын хэлтэс, Статистикийн хэлтэс, Орон нутгийн өмчийн газар, Боловсрол шинжлэх ухааны газар.</p> <p>Шивээговь суманд 4 байгууллага, 7 аж ахуйн нэгж хариуцсан нийтийн эдэлбэр газрын 50м хүртэлх талбайн хог хаягдал, цас, мөсийг цэвэрлэсэн.</p>	
3	Аймгийн Онцгой комиссоос зохион байгуулж байгаа “Малчдад туслья” аянд аж ахуй нэгж, байгууллагууд нэгдэх	2024.01.08	<p>Аймгийн онцгой комиссоос зохион байгуулж буй “Малчдад тусалъя” аяны хүрээнд 01 сарын 08-ны байдлаар нийт 19 байгууллага тусламж, дэмжлэг үзүүлсэн. Үүнд:</p> <p>Мөнгөн тусламж үзүүлсэн байгууллага: Аймгийн Засаг даргын Тамгын газар-1.140.000 Боржигин өв музей- 200.000 Стандарт хэмжил зүйн хэлтэс- 200.000 Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар-140.000</p> <p>Эд материал, хүнсний бүтээгдэхүүн, өвс тэжээлийн тусламж үзүүлсэн байгууллага: Сум дундын ойн анги- Хүнсний бүтээгдэхүүн Улсын бүртгэлийн хэлтэс- Дулаан хөнжил, хүнсний бүтээгдэхүүн Соёл урлагийн газар- Хүнсний бүтээгдэхүүн Нийтийн номын сан- Хүнсний бүтээгдэхүүн “Боржигидай сэцэн” салбар – Дархлаа дэмжих бүтээгдэхүүн Насан туршийн боловсролын төв- 15 метр малын хорооны дулаалга Цахилгаан түгээх газар- Малын тэжээл, дулаан хөнжил. Автотээврийн газар- Дулаан нэмнээ Социал Демократ Монголын эмэгтэйчүүдийн холбоо- Дулаан нэмнээ Биеийн тамир спортын газар- Дулаан нэмнээ Хөдөлмөр халамж үйлчилгээний газар- Хүнсний болон ахуйн хэрэглээний бүтээгдэхүүн, хүүхдийн дулаан хувцас.</p>	100

			<p>2 дугаар сургууль- өвс, дулаан нэмнээ, бээлий Онцгой байдлын газар- 120 ширхэг бод малын нэмнээ, Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар- 8 шуудай тэжээл Байгаль орчин аялал жуулчлалын газар- 3 шуудай тэжээл Хүнсний бүтээгдэхүүн, өвс тэжээл, дулаан хөнжил, бээлий, нэмнээ бэлэн мөнгө нийт 5.9 сая төгрөгийн бараа бүтээгдэхүүн хандивлан 5,6 багийн хүнд нөхцөлд байгаа 33 өрхөд 3.3 сая төгрөгийн тусламжийг хүргүүлээд байна.</p>	
4	УОК-ын шуурхай штабын 2023 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 06 дугаар албан бичгээр ирсэн үүргийг хэрэгжүүлэн сум, багийн Засаг дарга нар малчидтай хариуцлагын гэрээ байгуулах.	2024.01.08	<p>Сүмбэр сум 39, Шивээговь сум 59 малчин өрхтэй хариуцлагын гэрээг байгуулсан. Сүмбэр сум 24 малчин өрхөд үнэ төлбөргүй 16 тонн нүүрс, 81 өрхөд хөнгөлөлттэй үнээр 3.6 тонн тэжээл борлуулсан. Шивээговь сум 8 өрхөд эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлж, алдагдсан болон хорогдсон малын тоог бүртгэсэн.</p>	70
Дундаж				77.5

Хянасан: ХШҮХ-ийн дарга

М.Анхбаяр

Үүргийн биелэлт нэгтгэж, үнэлсэн:

ХШҮХ-ийн мэргэжилтэн

Б.Мөнхзаяа

